



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 22

Номгон

**Төрийн жинхэнэ албан хаагчийг тангараг  
өргүүлэх арга хэмжээ зохион байгуулах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 84 дүгээр зарлигийн хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

- 1.Төрийн жинхэнэ албан хаагчийг тангараг өргүүлэх арга хэмжээг “Төрийн албаны өдөр” буюу 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсугай.
- 2.Төрийн захиргааны албан тушаалд анх удаа, хууль ёсны дагуу, жинхлэн томилогдсон төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх эрх үүссэн албан хаагчдыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
- 3.Зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар, хөтөлбөрийг 3 дугаар, хавсралтаар тус тус баталсугай.
- 4.Тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг чанартай гүйцэтгэж, тайланг хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ